



МОНГОЛ УЛС  
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 27 өдөр

Дугаар А/503

Баруун-Урт сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Я.Батсугар захиралтай “Баатар сүлд” ХХК-ийн “Сүлд” хүнсний дэлгүүр, Баяндэлгэр сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Э.Эрдэнэцэнд захиралтай “Дархан бадрах өргөө” ХХК-ийн “Их-Өргөө” хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай сунгаж, Түвшинширээ сумын 1 дүгээр багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй Н.Аваадорж захиралтай “Түвшин ас бэт” ХХК-ийн “Ас бэт” хүнсний дэлгүүр, Дарьганга сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ш.Цагаанхүүхэн захиралтай “Баян-Баруун нарт” ХХК-ийн “Баян нарт” хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Д.Мөнхзул захиралтай “Цайдам Рашаан” ХХК-ийн “Нандин” хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Гэрэлмаа захиралтай “Түмэн ажнайн хурдны буян” ХХК-ийн “Хангай” хүнсний дэлгүүрт өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл сунгагдсан болон шинээр олгогдсон аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Гантулга), Мэргэжлийн хяналтын газар (С.Нямжав), Стандарт хэмжил зүйн хэлтэс (Д.Эрдэнэбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг дээрх аж ахуй нэгжүүдийн захирлуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ